

Наймдугаар сарын сүүлийн хагасд Ховд аймагт болсон олон улсын эрдэм шинжилгээний хуралд уригдан оролцсон хүндэт зочдын нэг ОХУ-ын Томскийн УИС-ийн проректор, ОХУ-ын шинжлэх ухааны гавъяат ажилтан, Монгол улсын ШУ-ны тэргүүний ажилтан, ХИС-ийн хүндэт доктор А.С.Ревушкинтай ярилцсан ярилцлагыг уншигчиддаа толилуулж байна. . -Хүндэт А.С.Ревушкин таныг дахин Ховд нутагт маань зочилж байгаа явдалд талархан мэндчилье. Та энэ удаад ямар зорилготой ирэв? -Энэ зуны хувьд бид олон томоохон ажлыг орнүүлж, хамтран ажиллаж байгаагийн нэг нь наймдугаар сарын сүүлч дээр танай Ховд хотод болж байгаа олон улсын эрдэм шинжилгээний арав дахь удаагийн хуралд оролцохоор хүрэлцэн ирсэн явдал юм. Ажил торлийн шугамаар урьдын дотно харилцаатай Ховд нутагт дахин ирсэндээ ихэд баяртай байна.

-Ховд нутагт омо нь хэдэн хэдэн удаа ирж байсан гэж сонссон. Анх ирснээс хойш Ховд нутаг хэрхэн оорчлогдож вэ гэдэг тухайд таны ярихыг сонсох нь сонирхолтой санагдаж байна? -Бид холбоо харилцаа тогтоож, ирж очих болсноор үндсэндээ арван таван жилийн нүүрийг үзжээ. Миний ажигласнаар урьдын танил Ховд аймаг, байнгын харилцаатай байдаг Ховд их сургуулийн хөгжилд нэлээн үсрэнгүй оорчлолт гарсан байна. Миний хувьд анх 1996 онд энд ирж байсан. Түүнээс хойш олон удаа ирсээн. Ирсэн цагаас минь Ховд ихээхэн анхаарал татах болсон. Тэгэхэд гэрэл цахилгаангүй хүнд үе ч байсан, бараа таваар ч хомс цаг байсан. Гэхдээ хамгийн гол нь хүмүүс амьдралаа цогцлоохыг хичээж эрмэлзэж байсныг мэдэх юм. Гадаад харилцааны тухайд тэр үед эхлэл сууриудыг тавих угтал нохцол л бүрэлдэж байсан болов уу? Одоо бол тэрхүү арван таван жилийн онохоос эрс оор болсныг би омо нь хэлсэн. Энэ нь мэдээж аймгийн удирдлагын зүгээс явуулж буй бодлого, Орнүүлж буй томоохон үйл ажиллагаануудтай холбоотой гэдгийг хэлэх байна. Нэгэн цагт энд орос зовлолтоос олон хүмүүс ирж ажиллаж амьдарч байсныг бас санах юм.

Энэ жил Ховд аймгийн түүхэнд онцгой үйл явдал орнож, үүсэн байгуулагдсаныхаа 80 жилийн ойг тэмдэглэжээ. Сүүлийн доргов таван жилийн хугацаанд Ховд аймгийн хөгжил, бидний хамтын ажиллагаа аль аль нь улам ч эрчимжиж байна. -Оорийн удирдаж ажилладаг Томскийн УИС-ын талаар манай уншигчдад танилцуулна уу? -Томскийн их сургууль болон Ховд их сургуулийн хооронд олон талын хамтын ажиллагааг нэлээд оргон хэмжээгээр орнүүлж ирсэн нь цаашид улам гүнзгийрэх учиртай. Тэрээр шинжлэх ухаан боловсролын салбарт харилцан уялдаатайгаар хамтран ажиллаж буй нь хоёр талын харилцааны томоохон ололттой тал нь гэж болно. Оноогийн нохцолд манай Томскийн их сургууль сургалт эрдэм шинжилгээний үйл ажиллагаандаа шинэ нохцол байдлыг бий болгож, шинэ хотолборийг нэвтрүүлэн ажиллаж байгаа. Энэ нь харьцангуй цоохон оронд нэвтэрсэн хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт хотолбор, ажиллагаа богоод дэлхий дахины шинжлэх ухаан, боловсролын үйл ажиллагаанд зайлшгүй нэвтрүүлэх шаардлагатай хотолбор юм. ДЭЛГЭРЭНГҮЙ -Таны судалгааны ажлын чиглэл, бүтээл туурвилын тухайд сонирхож болохсон болов уу? -Миний хувьд шинжлэх ухааны

судалгааны хэд хэдэн торлоор ажиллаж ирлээ. Ер нь миний судалгааны чиглэлийг Потаник, экологи, географи гэсэн шинжлэх ухааны салбаруудын холбоо харилцаан дунд ойлгож болно. Сvvлийн жилvvдэд миний хийж хэрэгжvvлж буй олон талт ажлуудын нэг нь их сургуулийн боловсрол, шинжлэх ухаан, судалгааны тvvхэн хогжлийг тодорхой дэвшилд хvргэх явдал. -Ховд нутаг болон Монгол орны баруун бvс нутагт шинжлэх ухаан, дээд боловсрол хогжиход таны тусламж дэмжлэг, хувь нэмрийг манай боловсрол, эрдэм шинжилгээ судалгааны салбарт ихэд vнэлдэг юм билээ.

Ер нь орон нутгийн хогжилд их сургууль, шинжлэх ухааны байгууллагын vvрэг, ач холбогдлын талаар та ямар бодолтой байдаг вэ? -Муж болон нутаг орны хогжлийн асуудалд их сургуулийн vvрэг роль асар их. Миний хувьд сургалт эрдэм шинжилгээ судалгааны энэхvv томоохон институтаас оортоо их зvйлийг олж, шингээж авсан. Хорьдугаар зууны дунд вейг дуустал Сибирийн бvс нутаг цоллогийн газар байлаа. Гэмт хэрэгтнvvд хэмээгдэх таагvй нэр зvvсэн хvмvvсийг тийш нь илгээдэг байв. Гэвч ногоо онцгоос харвал тэд тийм ч муу хvмvvс байгаагvй. Тvvхийн ийм цаг вeд тухайн газарт Томскийн их сургууль оршин тогтнож, боловсрол гэгээрлийн уурхай болж байлаа. Тэрээр Оросын энэ бvс нутагт Хаант засгийн вeд бий болсон анхны их сургууль. Тэр ч vвднээсээ хот болон муж улсын шинжлэх ухаан, соёл, боловсрол тэрчлэн бусад салбарын хогжилд ихээхэн тvлхэц vзvvлж, ухаалаг бодлого, ухаалаг чиг хандлага бvхий хот болгон хогжиход чухал нолоо vзvvлж байдаг.

Yвнтэй адилхан Ховд хотод байгуулагдаж бэхжсэн Монгол орны баруун бvс нутаг дахь ууган их сургууль Ховд их сургуулийн тухайд мон л оорийн аймгийнхаа болон энэ бvс нутгийн шинжлэх ухаан, боловсрол соёлын тов нь болон эрчимтэй хогжиж байна гэж боддог. Монгол улсад миний очиж байсан аймгуудаас Ховд аймаг юугаараа ялгагддаг гэвэл боловсон хvчний нооцоороо. Жил бvр олон зуун шинэ оюутан, шинэ багш нараар онго жавхаагаа чимж байдаг нь бусдаас давуу юм. - Ховд их сургуультай тогтоосон хамтын ажиллагааныхаа талаар бидэнд тодорхой мэдээлэл огч болох уу? -1996 онд Томскийн их сургуулийн толоолон Монгол улсын Ховд аймаг дахь Ховд их сургууль тэр вейн МУИС-ын салбар сургуулийн захирлын урилгаар зочилсон нь харилцаа хамтын ажиллагааны эхлэл болсон. Ийнхvv хамтын ажиллагааны эхлэлийг тавьсны vр дvнд дараа жил нь буюу 1997 онд томоохон экспедиц бvрэлдvvлж, эрдэм шинжилгээ судалгааны вйл ажиллагаа хэлэлцээрийг орнvvлснээр маш чухал нэг санаачлагыг хэрэгжvvлэх боломж олдсон нь гурван улс vндэснийг хамарсан эрдэм шинжилгээний хотолбор арга хэмжээ юм.

Омно нь Ховд их сургуулийн захирлаар ажиллаж байсан Г.Нямдаваа, одоогийн ректор Ш.Ванчинхvv нар энэхvv улс vндэстэн, ард тvмнvvдийн хамтын ажиллагааны орнол хогжилд томоохон тvлхэц, шийдвэрлэх нолоо vзvvлж байгааг холбогдох ном материал, хэвлэл зэргээс уншиж байдаг. Хамтарсан эрдэм шинжилгээ, судалгаа, боловсрол соёлын

хотолбор маань улам оргожиж, оноодрийн энэ хуралд гэхэд ОХУ-ын АБНУ-ын Алтайн их сургууль, Бийскийн их сургууль, Тувагийн улсын их сургууль, ГорноАлтайн их сургууль, Новосибирскийн эрдэм шинжилгээний хврээлэн, БНХАУ-ын Шинжаний их сургууль, Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын их сургуулиуд болон бусад олон сургалт эрдэм шинжилгээний байгууллагаас эрдэмтэн судлаачид оролцлоо. Бараг санаснаас илүү олон орны томоохон институтын эрдэмтэн судлаачид оролцсон оргон агуулга, ач холбогдолтой хурал болж ондорлож байна. -Томскийн УИС-ын проректороор машинаа твлхүүлж байсандаа ичиж санаа зовдог гэж Нямдаваа даргын ярьж байхыг сонссон. Хамтран ажилласан олон жилд сонирхолтой зүйл олон байсан байх?

-Аймгийн Засаг дарга Г.Нямдаваа тэр вед их сургуулийн захирлаар ажиллаж байлаа. ОХУ-ын баруун Сибирийн Томск хотод европийн их сургуулийн захирал, багш нарын зовлодох уулзалт зохион байгуулагдаж захирал Г.Нямдаваа очиж оролцсон юм. Тэндээс буцахад нь үдэж огох хооронд машин нь саатаж бид тусалсан тийм явдал болж байсныг санаж байна. Энэ бол хоёр талийн хамтын ажиллагааны тvvхэнд бидний сэтгэл санаанд үлдсэн дурсамжтай зүйлүүд юм даа. -Орнүүлж буй хамтын ажиллагааныхаа үр огоожийн талаар таны бодож буй зүйлийг сонирхож болох уу? -Хоёр сургуулийн хамтын ажиллагааны үр дvнгийн тухайд гэвэл олон тооны хамтарсан экспедици, хотолборvvдийг дурьдаж болно. Тэдгээрийн нэг нь Алтайн бvсийн унаган ургамлуудыг хамгаалахад чиглэсэн олон улсын тосолт ажил байлаа. Энэ тослийн судалгаанд Их Британи, Дорнод Казахстан, ОХУ /Томскийн УИС/, Монголын /Ховд их сургууль/ эрдэмтэд хамтран ажилласан юм. Миний бие энэ тосолд удирдагчийн үүрэгтэйгээр оролцож билээ. Тэрээр энэ тослийн судалгаанд Ховд их сургуулийн багш судлаачид мон Томскод суралцаж буй багш судлаачид оролцон ажиллаж томоохон бvтээл туурвил хийсэн юм. Томскийн их сургуульд уг судалгааны хврээнд эрдэм шинжилгээний чухал үгvүллүүд хэвлэгдсэн ба Томскийн их сургуульд суралцаж байсан Н.Монхжаргалын хийсэн эрдэм шинжилгээ судалгааны ажлууд тодорхой байр зайг эзлэж байгаа.

Тэрчлэн энэ тослийн хврээнд судалгаа шинжилгээний оор олон бvтээлүүд бэлтгэгдэн, сонирхогч судлаачдын хвртээл болсныг дурьдах байна. -Манай ХИС-ийн олон багш, судлаачид танай сургуульд эрдмийн зэрэг хамгаалсан. Манай багш нарын талаар таны санал, дvгнэлтийг сонсьё. -Тиймээ. Ховд аймгаас Манай сургуульд очиж сурч боловсорсон олон сайн оюутныг нэрлэж болох байна. Сvvлийн жилүүдэд гэхэд ургамлын хими, байгаль судлалын чиглэлээр сурч, ажиллан, докторын зэрэг хамгаалсан Н.Монхжаргалыг манай багш нар их үнэлдэг. Надад ч ондор сэтгэгдэл үлдээсэн. Тэр фитоэкдистероид гэдэг бодисын судалгааг хийсэн нь Монгол нутгийн ургамлын аймагт хийсэн анхдагч судалгаа болсон. Манай тогсогч Н.Монхжаргал доктор одоо Улаанбаатарт мэргэжлээрээ амжилттай ажиллаж байгаа. Бас Дашцэрэн гэж оюутныг сайн санаж байна.

Дашцэрэн бас Улаанбаатар хотод ажиллаж байна. -Манай аймагт "Оюунлиг Ховд" хотолбор хэрэгжиж, боловсрол, шинжлэх ухаан, хvний хогжилд онцгой анхаарч байна. Ховд нутгийн байгаль, хvн ардын ёс заншил, тvvx соёл гээд судалж тодорхойлох олон зvйл бий. Иймд аймгийн Засаг дарга маань санаачлан "Ховд судлалын тов" байгуулсан. Та хурлын нээлтэн дээр энэ судалгааны товийн тухай онцлон дурдаж байсан. Энэтовтэй цаашид хамтран ажиллах боломж бий юу? -Ховд аймагт болж буй вйл явдлын талаар миний хамгийн сvүлд сонссож мэдсэн шинэ мэдээлэл Ховд судлалын тов хэмээх байгууллагыг бий болгосон тухай бас Оюунлаг Ховдчууд сэтгvүл эрхлэн гаргаж буй тухай юм. Зовхон надад тодийгвй энд ирсэн бусад судлаач эрдэмтэдэд энэ санаачлага ажил хэргvүд ондор сэтгэгдэл торvүлж байгаа гэж би хувьдаа бодож байна. Биднээс гадна эрдэм шинжилгээ судалгааны олон байгууллага судлаачид шинээр бий болсон тэрхvү товтэй хамтран ажиллана гэдэгт найдаж байна.

-“Оюунлиг Ховдчууд” сэтгvүлийг бид цаашид орос, англи, хятад хэл дээр хэвлэх бодолтой байгаа. Монгол орны баруун бvс нутгийг судалсан эрдэмтэн хvний хувьд таны бvтээл, туурвилаас танилцуулах бодол ч бас бий. Тэгэхээр та бидэнтэй хамтран ажиллана биз дээ? -“Оюунлаг Ховдчууд” сэтгvүл гаргаж буй явдал бол маш чухал зvйл Томскийн их сургуулиас энэ сэтгvүл болоод Ховд судлалын товтэй хамтран ажиллана гэж бодож байна. Хамтын ажиллагааны бас нэг шинэ боломж орон зай нээгдэж байна гэсэн vг. Тэрчлэн энэ тухайд баруун Монголын тvvx соёл угсаатны судалгааны чиглэлээр хамтран ажиллах боломжтой. Томскийн их сургууль, Томскийн эрдэмтэд энэ чиглэлийн судалгааны анхны томоохон экспидицийг бий болгож, баруун Монголын тvvx, соёлын судалгааг эргэлтэнд оруулахад тодорхой vүрэг гvйцэтгэсэн бэлээхэн туршлага бий.

Анхны экспидицийг их эрдэмтэн Григорий Николаевич Потанин харин хорьдугаар зууны дунд вед бий болсон хоёр дахь экспидицийг профессор Василий Василевич Сапожников удирдаж байв. Эдгээр экспидицийн эрдэмтэн судлаачдын бvтээлvүд Томскд том боть болон хэвлэгдсэн. Эл бvтээлээс баруун Монгол тvмний ахуй соёл, байгалийн нохцол,эдийн засаг, худалдаа гээд оргон сэдэв агуулга бvхий зvйлийг олж vзэх болно. Оноогийн бидний орнvүлж буй эдгээр хамтын ажиллагаа бол омо нь суурийг нь тавьсан тэдгээр ажлын vргэлжлэл юм.

Одоо болж ондорлож буй олон улсын эрдэм шинжилгээний хуралд Томскийн их сургуулийн эрдэмтэн судлаачид маань чамгvй олон бvтээл илтгэлvүдийг хэлэлцvүллээ. Тухайлбал технографийн цогц судалгааны илтгэл, гэрэл зургийн судалгаа, соёл, хvмvүнлэгийн чиглэлийн илтгэлvүдийг хэлэлцvүллээ. Үвний зэрэгцээ эрдэм шинжилгээний судалгааны тvвшинд цаашид шинэлэг вйлс морийг эхлvүлэх суурь сурвалж болсон зvйлvүд ч байсныг дурьдах хэрэгтэй. Бидний хамтын ажиллагаа цаашид улам оргожин гvнзгийрэх болно. Сонин болон оргон мэдээллийн цахим хуудасныхаа зочноор урьж ярилцсанд баярлалаа. -Бидний урилгыг хvлээн авч элэгсэг дотно яриа орнvүлсэн

танд ч бас баярлалаа. ЯРИЛЦСАН Г.ТОРМОНХ